



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

Чингисийн өргөн чөлөө, 20 дугаар хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17043
Утас: 34 18 17, Факс: (976-11) 34 18 16,
Цахим шуудан: info@clem.namem.gov.mn,
Цахим хуудас: www.clem.namem.gov.mn

2026.03.02 № 16
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөлд санал хүргүүлэх тухай

Тус байгууллагын нийт албан хаагчдын хурлаар “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай” /Шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг хэлэлцэж, дараах саналыг нэгтгэн хүргүүлж байна. Үүнд:

Хуулийн төслийн:

1. 1.1 дэх хэсэгт хуулийн зорилтыг зөвхөн хяналт шинжилгээ хийх, мэдээ мэдээллээр хангах хүрээнд тодорхойлсон нь хязгаарлагдмал байгаа тул тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй ажилтнуудын нийгмийн баталгааг хангах зохицуулалт орсон тухай нэмэх;
2. 3.1 дэх хэсгийг хуулийн үйлчлэх хүрээг зөвхөн уур амьсгалын асуудлаар хязгаарласан тул өргөжүүлэн, дахин найруулах;
3. 4.1.16 дахь заалтын “...хүн” гэснийг хасах;
4. 8.1.7 дахь заалтад “агаарын чанарын хяналт шинжилгээний станц” гэж нэмэх;
5. 20.2 дахь хэсэг “20.2.Агаарын чанарын хяналт шинжилгээг Агаарын тухай, усны хяналт шинжилгээг Усны тухай, хөрсний доройтол, цөлжилтийн төлөв байдлын судалгаа, дүгнэлтийг Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулиар тус тус зохицуулна.” гэснийг “20.2.Агаар, ус, хөрсний чанарын хяналт шинжилгээг төрийн захиргааны төв байгууллагын баталсан хөтөлбөр (төслийн 9.3 дахь заалт)-ийн дагуу хийж гүйцэтгэнэ.” гэж өөрчлөн найруулах;
6. 30.1 дэх хэсэгт “Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори” гэснийг “Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори” гэж засах;
7. 30.5 дахь хэсэгт “...албадын” гэснийг “...байгууллагын” гэж өөрчлөх;
8. 33.3.1 дэх заалтад “ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албанд 20 ба түүнээс дээш жил ажилласан ажилтанд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Төрийн албаны тухай хуульд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламж олгох” гэж заасан нь Төрийн албаны тухай хуулиар зохицуулах боломжтой харилцаанд нэмэлт, хэт өндөр шалгуур тогтоож байна. Иймд салбарт ажилласан хугацааг заасан нөхцөлийг хасах;
9. 34.1.6 дахь заалтад “Орчны хяналт шинжилгээний үйлчилгээ” гэж нэмэх;
10. 34.3 дахь хэсэгт “...34.1.2–34.1.6-д...” гэж нэмэх;

11. “34.1.5. хэмжилт, ажиглалтын багаж хэрэгслийг баталгаажуулах үйлчилгээ”-ний үнэ тарифыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулиар эрх бүхий Засгийн газрын гишүүн тогтоодог тул төслийн 34.4 дэх хэсгийн “...34.1.5...” гэснийг хасах;

12. 34.4 дүгээр хэсэгт “...34.1.5-д” гэснийг “34.1.6” гэж өөрчлөх саналтай байна.

ЗАХИРАЛ *Машраал* Б.ЦАЦРАЛ

